



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
“Анализ старт аудит” ХХК-ийн Ахлах аудитор А.Батжаргал
Утас: 99291595
Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.МӨНХНАСАН ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

᠒᠐᠒3.᠐2.᠒᠐ № ᠒᠑
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 90.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702000150

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,286.4	6,572.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	207,121.8	219,582.6
	Нийт хөрөнгийн дүн	218,408.2	226,155.0
	Нийт өр төлбөрийн дүн	-	776.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	218,408.2	225,378.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	218,408.2	226,155.0
	Үйл ажиллагааны орлогын дүн	382,047.3	286,630.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	314,090.1	279,647.8
	Үйл ажиллагааны үр дүн	67,957.2	6,982.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	12.5
	Үйл ажиллагааны нийт үр дүн	67,957.2	6,970.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,451.0	218,408.2
	Тайлант оны үр дүн	67,957.2	6,970.0
	Эцсийн үлдэгдэл	218,408.2	225,378.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	380,261.9	258,253.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	289,899.3	253,995.6
	Үйл ажиллагааны ЦМГ	90,362.6	4,258.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(90,362.6)	(4,258.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	263,273.7	257,853.2
	Урсгал зардал	263,273.7	257,853.2
	Хөрөнгийн зардал	0.0	0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	263,273.7	257,853.2
	Улсын төсвөөс санхүүжих	224,223.7	223,823.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	39,050.0	34,030.0
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0	0


Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа илрээгүй.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

- ✓ Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч тоолуур тавиулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур



ашиглах; заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	1	-	-	-	1	-	-	-
Нийт дүн	1	-	-	-	1	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-